



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 140

Улаанбаатар хот

Хорооны 2009 оны 211 дүгээр тогтоолоор  
батлагдсан журамд нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам”-ын 3.3.10 дахь заалтын “...хогшил,” гэсний дараа “тээврийн хэрэгсэл,” гэж нэмсүгэй.

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам”-ын 2.6.3 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/ 2.6.3 дахь заалт:

“2.6.3 Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон дүрмийн сангийн (хувь нийлүүлсэн хөрөнгийн) доод хэмжээ.”

3. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам”-ын 3.3.3 дахь заалтыг хассугай.

4. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

001487